



ХҮН АМЫН БОДЛОГО, ХӨДӨЛМӨРИЙН САЙД, САНГИЙН САЙДЫН ХАМТАРСАН ТУШААЛ

1996 оны 4 дүгээр сарын 20-ны өдөр

Дугаар 63/104

Улаанбаатар хот

ЖУРАМ БАТЛАХ ТУХАЙ

"Төрийн албаны тухай" хуулийн 28 дугаар зүйлийн 2 дахь заалтын 4, Засгийн газрын 1995 оны 96 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн үйлчилгээний албаны албан хаагчид ур чадварын нэмэгдэл олгох нийтлэг журам"-ын 8 дугаар заалтыг үндэслэн төрийн үйлчилгээний албаны түгээмэл мэргэжлийн албан хаагчдын ажлын үр дүнг дээшлүүлэх зорилгоор ТУШААХ нь

- 1.Төрийн үйлчилгээний албаны түгээмэл мэргэжлийн албан хаагчдад ур чадварын нэмэгдэл олгох журмыг хавсралтаар баталсугай.
- 2.Журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хүн амын бодлого, хөдөлмөрийн яамны Хөдөлмөрийн газар /Д.Жанцан/, Сангийн яамны Төсвийн төлөвлөлт, санхүүжилтийн газар /Ц.Батнасан/-т үүрэг болгосугай.

ХҮН АМЫН БОДЛОГО, САНГИЙН САЙДЫН Э.ГОМБОЖАВ
ХӨДӨЛМӨРИЙН САЙД Э.БЯМБАЖАВ



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2018 оны 12 дугаар сарын 19-ний өдөр

Дугаар 382

Улаанбаатар хот

ЖУРАМ БАТЛАХ ТУХАЙ

Төрийн албаны тухай хуулийн 57.7, 57.8, 57.12, 77.1 дэх хэсэгт заасныг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгох журам"-ыг 1 дүгээр хавсралт, "Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид нэмэгдэл хөлс олгох журам"-ыг 2 дугаар хавсралт, "Төрийн албан хаагчид докторын зэрэг, профессор цолны нэмэгдэл олгох журам"-ыг 3 дугаар хавсралт, "Төрийн үйлчилгээний албан хаагчид ур чадварын нэмэгдэл олгох нийтлэг журам"-ыг 4 дүгээр хавсралт, "Төрийн үйлчилгээний албан хаагчид мэргэшлийн зэргийн нэмэгдэл олгох нийтлэг журам"-ыг 5 дугаар хавсралт, "Төрийн захиргааны, үйлчилгээний болон улс төрийн албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчид орон нутгийн нэмэгдэл олгох журам"-ыг 6 дугаар хавсралт, "Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагчид хөдөлмөрийн нөхцөлийн нэмэгдэл олгох журам"-ыг 7 дугаар хавсралт, "Хөгжлийн бэрхшээлтэй хүн, ахмад настанд тусламж, үйлчилгээ үзүүлж байгаа төрийн үйлчилгээний зарим албан хаагчид хөдөлмөрийн нөхцөлийн нэмэгдэл олгох журам"-ыг 8 дугаар хавсралтын ёсоор тус тус баталсугай.

(Энэ тогтоолын 2 дугаар хавсралтад Засгийн газрын 2019 оны 126 дугаар тогтоол, Засгийн газрын 2022 оны 490 дүгээр тогтоолоор тус тус нэмэлт, өөрчлөлт орсон. Засгийн газрын 2020 оны 151 дүгээр тогтоолоор 1, 2, 5-7 дугаар хавсралтад нэмэлт, өөрчлөлт орсон. Засгийн газрын 2022 оны 491 дүгээр тогтоол, Засгийн газрын 2023 оны 15 дугаар тогтоолоор 1 дүгээр хавсралтад нэмэлт, өөрчлөлт орсон. Засгийн газрын 2022 оны 489 дүгээр тогтоолоор 1 дэх заалт болон 6 дугаар хавсралтад нэмэлт орсон. Засгийн газрын 2023 оны 242 дугаар тогтоолоор 2, 6 дугаар хавсралтад нэмэлт, өөрчлөлт орсон бөгөөд үүнийг 2023-01-01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө. Засгийн газрын 2024 оны 12 дугаар тогтоолоор 7 дугаар хавсралтад нэмэлт, өөрчлөлт орсон. Засгийн газрын 2024 оны 82 дугаар тогтоолоор 6 дугаар хавсралтыг өөрчилсөн бөгөөд үүнийг 2024-04-01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө. Энэ тогтоолын 1 дэх заалт болон 6 дугаар хавсралтад Засгийн газрын 2024 оны 171 дүгээр тогтоолоор нэмэлт, өөрчлөлт орсон)

2. Энэ тогтоолын 1, 3, 4, 5, 6, 7, 8 дугаар хавсралтаар тус тус баталсан төрийн албан хаагчид олгох нэмэгдлийг тооцох үндсэн цалингийн хэмжээг тодорхойлохдоо Засгийн газраас баталсан төрийн захиргааны болон улс төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн хэмжээ, төрийн үйлчилгээний албан хаагчийн цалингийн доод хэмжээг тус тус баримтална.

(Засгийн газрын 2025 оны 225 дугаар тогтоолоор нэмсэн)

3. Энэ тогтоолын 2 дахь хэсэгт Улсын Их Хурал, Шүүхийн ерөнхий зөвлөлийн тогтоолоор албан тушаалын цалингийн хэмжээ, цалингийн хэмжээ тогтоох итгэлцүүр баталдаг төрийн захиргааны, үйлчилгээний болон улс төрийн албан хаагчид хамаарахгүй.

(Засгийн газрын 2025 оны 225 дугаар тогтоолоор нэмсэн)

4. Төрийн албаны тухай хуульд тусгайлан зааснаас өөрөөр төрийн албан хаагчид нэмэгдэл, нэмэгдэл хөлс тогтоохгүй байхыг төсвийн байгууллагын төсвийн ерөнхийлөн захирагч, төсвийн төвлөрүүлэн захирагч, төсвийн шууд захирагч нарт даалгасугай.

5. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Төрийн албан хаагчийн нэмэгдэл олгох журам батлах тухай" Засгийн газрын 1995 оны 6 дугаар сарын 14-ний өдрийн 96 дугаар тогтоолын 2, 3, 4, 5 дугаар хавсралт, "Тогтоолын заалт өөрчлөн найруулах тухай" Засгийн газрын 1996 оны 4 дүгээр сарын 23-ны өдрийн 90 дүгээр тогтоол, "Төрийн албан хаагчийн цалингийн талаар авах зарим арга хэмжээний тухай" Засгийн газрын 1998 оны 4 дүгээр сарын 15-ны өдрийн 52 дугаар тогтоол, "Төрийн үйлчилгээний зарим албан хаагчдын цалингийн нэмэгдлийн тухай" Засгийн газрын 2001 оны 4 дүгээр сарын 20-ны өдрийн 90 дүгээр тогтоол, "Боловсролын салбарын албан хаагчдын нэмэгдэл хөлсний хувь хэмжээг тогтоох тухай" Засгийн газрын 2007 оны 9 дүгээр сарын 5-ны өдрийн 219 дүгээр тогтоол, "Нэмэгдлийн хэмжээг батлах тухай" Засгийн газрын 2010 оны 5 дугаар сарын 5-ны өдрийн 108 дугаар тогтоол, "Тогтоолд өөрчлөлт оруулах тухай" Засгийн газрын 2010 оны 6 дугаар сарын 9-ний өдрийн 148 дугаар тогтоол, "Эрдэм шинжилгээний ажилтны зэрэг дэвийн нэмэгдлийн хэмжээг тогтоох тухай" Засгийн газрын 2012 оны 2 дугаар сарын 15-ны өдрийн 50 дугаар тогтоол, "Эрүүл мэндийн ажилтанд нэмэгдэл хөлс олгох тухай" Засгийн газрын 2012 оны 5 дугаар сарын 2-ны өдрийн 151 дүгээр тогтоол, "Эрүүл мэндийн ажилтанд нэмэгдэл, мөнгөн урамшил олгох

журам батлах тухай" Засгийн газрын 2012 оны 5 дугаар сарын 2-ны өдрийн 150 дугаар тогтоол, "Журам батлах, тогтоолд нэмэлт оруулах тухай" Засгийн газрын 2013 оны 6 дугаар сарын 26-ны өдрийн 229 дүгээр тогтоолын 2 дахь заалт, "Тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай" Засгийн газрын 2013 оны 1 дүгээр сарын 26-ны өдрийн 29 дүгээр тогтоол, "Журамд нэмэлт оруулах тухай" Засгийн газрын 2017 оны 9 дүгээр сарын 20-ны өдрийн 275 дугаар тогтоолыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

6. Төрийн албан хаагчид нэмэгдэл, нэмэгдэл хөлс олгохтой холбоотой Засгийн газрын гишүүний дангаар болон хамтран баталсан шийдвэрийг шинэчлэхийг холбогдох Засгийн газрын гишүүдэд даалгасугай.

7. Төрийн захиргааны албан хаагчийн нэмэгдэл хөлс, төрийн үйлчилгээний албан хаагчийн төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг 2020 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс, захиргааны албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчид орон нутгийн нэмэгдлийг 2023 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс тус тус эхлэн тооцож олгосугай.

(Энэ заалтад Засгийн газрын 2022 оны 489 дүгээр тогтоолоор нэмэлт орсон)

8. Энэ тогтоолыг 2019 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

(Энэ тогтоолын 2-6 дугаар зүйлийн дугаарлалтыг Засгийн газрын 2025 оны 225 дугаар тогтоолоор өөрчилсөн)

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД У.ХҮРЭЛСҮХ

ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЙД С.ЧИНЗОРИГ

Хүн амын бодлого, хөдөлмөрийн сайд,

Сангийн сайдын 1996 оны 63/104 дүгээр тушаалын хавсралт

ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АЛБАНЫ ТҮГЭЭМЭЛ МЭРГЭЖЛИЙН АЛБАН

ХААГЧДАД УР ЧАДВАРЫН НЭМЭГДЭЛ ОЛГОХ НИЙТЛЭГ ЖУРАМ

1.Төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад зохих үүрэг гүйцэтгэдэг түгээмэл мэргэжлийн үйлчилгээний албан хаагч /нягтлан бодогч, боловсон хүчний ажилтан, нарийн бичгийн дарга, архив бичиг хэрэг, бичээч, нярав, жолооч, мужаан, слесарь, цахилгаанчин, үйлчлэгч, жижүүр болон тэдгээртэй адилтгах албан тушаал/-дад ур чадварын нэмэгдэл олгоход энэхүү журмыг баримтална.

2.Эрхэлсэн ажлаа мэргэжлийн өндөр түвшинд тогтмол сайн гүйцэтгэдэг буюу бусдаас илүү идэвхи санаачилга, өндөр үр дүнтэй ажиллаж байгаа түгээмэл мэргэжлийн албан хаагчдад дараах үндсэн шалгуур үзүүлэлтийг харгалзан ур чадварын нэмэгдэл олгоно.

Албан тушаал	Шалгуур үзүүлэлт
Нягтлан бодогч, нярав, бүртгэл тооцооны бусад ажилтан	а.улирал, жилийн тайлан тэнцэл, төсвийн төслийг хугацаанд нь үнэн зөв гаргасан байх б.анхан шатны бүртгэлийн хөтлөлт, баримтын боловсруулалтыг тухай бүрт нь хийж, данс бүртгэлд тусгасан байх, в. Өр, авлагын барагдуулалтын байдал г.хөрөнгийн зарцуулалтад тогтмол хяналт тавьж, батлагдсан төсвийг хэтрүүлээгүй байх
Боловсон хүчний ажилтан	а.ажилтан нарын хувийн хэргийг тухай бүрт нь нээж, баяжилтыг зохих журмын дагуу хийж байх б.ажиллагсдын цалин хөлс, нэмэгдэлтэй холбогдуулан гаргасан тогтоол, шийдвэрийг хэрэгжүүлэх арга хэмжээг тухай бүр авч байх. в.ажилтан нарын мэдлэг, мэргэжлийг дээшлүүлэх талаар идэвх санаачлагатай ажиллаж, үр дүнд хүрсэн байх
Архив, бичиг хэргийн эрхлэгч, нарийн бичгийн дарга, түүнтэй адилтгах бусад албан тушаал	А.бичиг хэргийг эмх цэгцтэй хөтөлж, архивын бичиг баримтыг зохих журмын дагуу хадгалж, хамгаалах б.гаднаас ирсэн болон гадагшаа явуулж байгаа бичиг, хариутай бичгийн гүйцэтгэлд хяналт тавих в. Бичээч нарын ажилд байнга хяналт тавьж байх г. өгөгдсөн үүрэг даалгаврыг тухай бүр хөнгөн шуурхай чанартай гүйцэтгэж байх
Жолооч	а.өөрийн хариуцаж байгаа машин техникийг ариг гамтай эдэлж, техникийн үйлчилгээг тогтмол хийж байх, б.машин, техникийн бүрэн бүтэн байдлыг хангаж, бэлэн байдалд байлгах. в. шатахуун, тослох материалыг нормын дагуу хэмнэлттэй зарцуулж, тооцоог санхүүтэй тогтоосон хугацаанд хийж, замын хуудсыг зохих журмын дагуу хөтөлж байх.
Бичээч, оператор	а.бичиг баримтыг стандартын дагуу тогтмол зөв цэвэр, алдаагүй, түргэн шуурхай бичиж, олшруулдаг байх. Б.өөрийн хариуцаж буй бичгийн болон олшруулах машин. компьютер, техник хэрэглэлийг гамтай эзэмшиж, үйлчилгээ тохируулгыг тогтмол хийж, ажлын бэлэн байдлыг хангадаг байх,
Засварчин, цахилгаанчин, мужаан	а. эрхэлсэн ажлын чиглэлээр хариуцсан тоног төхөөрөмжийн найдвартай ажиллагаа, бүрэн бүтэн байдлыг хангаж засвар үйлчилгээг хугацаанд нь чанартай гүйцэтгэдэг байх. б. гарсан эвдрэл, гэмтлийг түргэн шуурхай, чанартай засварлах.
Харуул, жижүүр, манаач, үйлчлэгч зэрэг бага тушаалын албан хаагч	а. Ажлын байрны эмх цэгц нь үлгэр жишээ байж, ариун цэврийн шаардага хангасан байх. б. Эрхэлсэн ажлын чиглэлээр зөрчил, доголдол гаргаагүй байх в. Байгууллагын доторхи эд хогшлыг байнга цэвэр үзэмжтэй байлгаж, бүрэн бүтэн байдлыг хангах

3. Ур чадварын нэмэгдлийн дээд хэмжээ нь тухайн албан хаагчийн албан тушаалын сарын цалингийн 25 хувиас ихгүй байна.

4. Ур чадварын нэмэгдлийг зөвхөн тухайн албан тушаалыг эрхэлж буй хугацаанд жинхэнэ ажилласан цагт ноогдох албан тушаалын цалингаас тооцож сар тутам олгоно. Ажлын үр дүн буурсан нөхцөлд ур чадварын нэмэгдлийн хэмжээг бууруулах буюу олгохгүй.

5. Ажилтанд олгож байгаа ур чадварын нэмэгдлийг заасан хязгаарт багтаан нэмэгдүүлэх, бууруулах асуудлыг улирал бүр хэлэлцэн шийдвэрлэж байна.

3. Энэхүү нийтлэг журмыг үндэслэн байгууллагын захиргаа нь тухайн албан хаагчид эрхэлж буй ажлын үр дүнгээр ур чадварын нэмэгдэл олгох бусад шалгуур үзүүлэлт, нэмэгдлийн хэмжээг тусгасан журмыг боловсруулан баталж, мөрдүүлнэ.

7. Ур чадварын нэмэгдлийг ажилтнуудын цалинг нэмэх, амьдрал ахуйг харгалзах зэргээр хавтгайруулан олгохыг хориглоно.

8. Энэ журмыг 1996 оны 5 дугаар сарнн 1-нээс эхлэн мөрдөнө.

---оОо---

Засгийн газрын 2018 оны 382 дугаар

тогтоолын 1 дүгээр хавсралт

ТӨРИЙН ЗАХИРГААНЫ БОЛОН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АЛБАН ХААГЧИД

ТӨРИЙН АЛБА ХААСАН ХУГАЦААНЫ НЭМЭГДЭЛ ОЛГОХ ЖУРАМ

1. Төрийн албаны мэргэшсэн, тогтвортой байх зарчмыг хангах зорилгоор төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгоход энэ журмыг мөрдөнө.

2. Төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг тухайн төрийн албан хаагчийн төрийн байгууллагад ажилласан хугацааг харгалзан түүний албан тушаалын сарын үндсэн цалингаас дор дурдсан хувиар бодож олгоно: *(Энэ заалтыг Засгийн газрын 2022 оны 491 дүгээр тогтоолоор өөрчлөн найруулсан бөгөөд үүнийг 2023-1-1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө)*

Төрийн алба хаасан хугацаа (жилээр, сараар)	Албан тушаалын сарын үндсэн цалингаас бодох хувь
2 дахь жил (13 – 24 сар)	1
3 дахь жил (25 – 36 сар)	2
4 дэх жил (37 – 48 сар)	3
5 дахь жил (49 – 60 сар)	4
6 дахь жил (61 – 72 сар)	5
7 дахь жил (73 – 84 сар)	6
8 дахь жил (85 – 96 сар)	7
9 дэх жил (97 – 108 сар)	8
10 дахь жил (109 – 120 сар)	9
11 дэх жил (121 – 132 сар)	10
12 дахь жил (133 – 144 сар)	11
13 дахь жил (145 – 156 сар)	12
14 дэх жил (157 – 168 сар)	13
15 дахь жил (169 – 180 сар)	14
16 дахь жил (181 – 192 сар)	15
17 дахь жил (193 – 204 сар)	16
18 дахь жил (205 – 216 сар)	17
19 дэх жил (217 – 228 сар)	18
20 дахь жил (229 – 240 сар)	19
21 дэх жил (241 – 252 сар)	20
22 дахь жил (253 – 264 сар)	21
23 дахь жил (265 – 276 сар)	22
24 дэх жил (277 – 288 сар)	23
25 дахь жил (289 – 300 сар)	24
26 ба түүнээс дээш жил (301 ба түүнээс дээш сар)	25

Тайлбар: Энэ журмын 2-т заасан төрийн алба хаасан хугацааны “жилд” гэснийг “тухайн жил дуустал” гэж, “6-10 жилд” гэснийг “6 дахь жилийн эхнээс олгоно” гэж тус тус ойлгоно. *(Энэ тайлбарыг Засгийн газрын 2020 оны 151 дүгээр тогтоолоор хассан)*

3. Төрийн албан хаагчийн төрийн алба хаасан хугацаанд дараахь хугацааг оруулж тооцно:

1/ Төрийн албаны тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1-д заасан албан тушаалд ажилласан хугацаа;

2/ Төрийн албаны тухай хуулийн дагуу төрийн албан хаагч болсон иргэний 1990 оны 3 дугаар сарын 23-наас өмнө нам, олон нийтийн төв, орон нутгийн байгууллагад орон тооны албан тушаал эрхэлж байсан хугацааг төрийн алба хаасан хугацаатай адилтган тооцсон хугацаа;

3/ Улсын Их Хуралд суудалтай намын байгууллагад орон тооны албан тушаал эрхэлж байсан иргэн төрийн албанд шилжин ажиллавал намын байгууллагад ажилласан дээрх хугацааг төрийн алба хаасан хугацаанд оруулан тооцсон хугацаа;

4/ улсын төсөвт үйлдвэрийн газрын гүйцэтгэх захирал, захиргааны ажилтан, бусад ажилтан (хөлсөөр түр ажиллагч орохгүй)-аар 1996 оны 8 дугаар сарын 1-нээс 2008 оны 5 дугаар сарын 6-ны өдөр хүртэл ажилласан хугацаа, 2020 оны 04 дүгээр сарын 29-ний өдрөөс 2022 оны 12 дугаар сарын 31-ийг хүртэл өдрүүдэд Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн дагуу томилогдон ажилласан хугацаа; *(Энэ заалтад Засгийн газрын 2023 оны 15 дугаар тогтоолоор нэмэлт орсон)*

5/ төрийн албанд ажиллаж байх хугацаандаа дахин мэргэшсэн, шинээр мэргэжил эзэмшсэн, төрийн хөрөнгөөр зургаа хүртэлх сарын хугацаагаар давтан сурсан, мэргэжил, мэргэшлээ дээшлүүлэхээр суралцсан, зургаан сараас дээш хугацааны сургалтаар бэлтгэгдсэн хугацаа;

6/ төрийн албанд ажиллах хугацаандаа жирэмсний болон амаржсаны амралттай, хууль тогтоомжийн дагуу хүүхдээ асрах чөлөөтэй байсан хугацаа;

7/ төрийн байгууллагын дотоод журамд заасны дагуу чөлөөтэй байсан хугацаа;

8/ төрийн албанд ажиллах үедээ ажлаас үндэслэлгүйгээр халагдсаныг шүүхээр эгүүлэн тогтоосон бол уг шалтгаанаар ажилгүй байсан хугацаа;

9/ баривчлагдсан буюу цагдан хоригдсон этгээд гэмт хэрэг үйлдсэн нь нотлогдоогүйгээс суллагдсан, шүүхээс цагаатгах тогтоол гаргасан, гэмт хэргийн шинжгүйн улмаас эрүүгийн хэргийг хэрэгсэхгүй болгосон хугацаа;

10/ эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэх тухай шүүхийн тогтоолыг хүчингүй болгосон бол төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийг ял шийтгэсэн, баривчилсан, цагдан хорьсон, албан үүргээ биелүүлэхийг түр түдгэлзүүлсэн, эмнэлгийн байгууллагад байлгасан хугацаа;

11/сонсогчийн цэргийн сургуульд суралцсан хугацаа; (Засгийн газрын 2020 оны 151 дүгээр тогтоолоор нэмсэн)

12/хугацаат цэргийн алба хаасан хугацаа; (Засгийн газрын 2020 оны 151 дүгээр тогтоолоор нэмсэн)

13/нийгмийн шилжилтийн явцад ажил, хөдөлмөр эрхлээгүй буюу эрхлэх боломжгүй байсан иргэний 1990-1995 оны хооронд ажилласан жил тасарсан иргэнд аймаг, дүүргийн нийгмийн даатгалын байгууллагаас олгосон баталгаажилтын хуудсыг үндэслэн ажилласнаар нөхөн тооцуулсан хугацаа. *(Энэ заалтыг Засгийн газрын 2020 оны 151 дүгээр тогтоолоор нэмсэн)*

14/ Улсын Их Хурлын байнгын хорооны 2012 оны 05 дугаар тогтоолоор баталсан “Албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийн маягт, түүнийг бүртгэх хянах, хадгалах журам”-ын 2.2.6-д заасан стратегийн ач холбогдол бүхий дэд бүтцийн салбарт үйл ажиллагаа явуулдаг 500-аас дээш ажилтантай төрийн өмчит үйлдвэрийн газрын болон төрийн өмчит хуулийн этгээдийн гүйцэтгэх удирдлагын албан тушаалд ажилласан 2012 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс хойших хугацаа (зөвхөн төрийн албаны шалгалт өгөхөд тооцно). *(Энэ заалтыг Засгийн газрын 2023 оны 15 дугаар тогтоолоор нэмсэн)*

4. Төрийн албанд ажилласан хугацааг тогтоох үндсэн баримт нь хөдөлмөрийн дэвтэр, нийгмийн даатгалын дэвтэр байна.

5. Төрийн алба хаасан хугацааг байгууллагын хүний нөөцийн асуудал эрхэлсэн нэгж буюу ажилтан тодорхойлж, тухайн байгууллагын төсвийн шууд захирагчийн тушаалаар энэ журмын 2-т заасны дагуу нэмэгдэл олгох хувийг тогтооно.

6. Төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг тухайн байгууллага жил бүрийнхээ төсөвт тусгаж олгоно.

-----o0o-----

Засгийн газрын 2018 оны 382 дугаар

тогтоолын 2 дугаар хавсралт

ТӨРИЙН ЗАХИРГААНЫ БОЛОН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АЛБАН

ХААГЧИД НЭМЭГДЭЛ ХӨЛС ОЛГОХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1. Төрийн албаны тухай хууль (шинэчилсэн найруулга)-ийн 57.2.2, 57.2.4, 57.8, 57.12-т заасны дагуу төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид нэмэгдэл хөлс олгохтой холбоотой харилцааг энэ журмаар зохицуулна.

2. Энэ журмын 1-д заасан төрийн албан хаагчид Хөдөлмөрийн тухай хуульд заасан нэмэгдэл хөлс олгоход энэ журмыг удирдлага болгоно.

3. Хөдөлмөрийн тухай хуульд заасны дагуу төрийн байгууллагын дотоод журмаар тогтоосон өдрийн ажлын цагийг ажил олгогчийн санаачлагаар хэтрүүлэн ажиллуулахыг илүү цагаар ажиллуулсанд, орон нутгийн цагаар 22 цагаас 06 цаг хүртэлх хугацаанд ажиллуулахыг шөнийн цагаар ажиллуулсанд, нийтээр амрах баярын өдрүүдэд ажиллуулахыг нийтээр амрах баярын өдөр ажиллуулсанд, Бямба, Ням гарат ажиллуулахыг долоо хоног бүрийн амралтын өдөр ажиллуулсанд тус тус тооцож, нөхөн амруулаагүй тохиолдолд нэмэгдэл хөлс олгоно.

4. Хөдөлмөрийн тухай хуульд заасны дагуу дор дурдсанаас бусад тохиолдолд төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийг ажил олгогчийн санаачлагаар илүү цагаар ажиллуулахыг хориглоно:

4.1. улс орныг батлан хамгаалах, хүний амь бие, эрүүл мэндийг хамгаалахад зайлшгүй шаардлагатай ажил гүйцэтгүүлэх, цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн хүүхдийн аюулгүй байдал, эрх ашгийг хамгаалах; (Энэ дэд заалтад Засгийн газрын 2019 оны 126 дугаар тогтоолоор нэмэлт орсон)

4.2. гамшиг, аюулт үзэгдэл, ослоос сэргийлэх, тэдгээрийн хор уршгийг нэн даруй арилгах;

4.3. нийтийн усан хангамж, цахилгаан, дулааны эрчим хүч, тээвэр, холбооны хэвийн ажиллагааг алдагдуулсан гэмтлийг арилгах;

4.4. урьдчилан мэдэх боломжгүй бөгөөд яаралтай хийхгүй бол тухайн төрийн байгууллагын буюу түүний харьяа нэгжийн хэвийн үйл ажиллагаанд учирч болзошгүй саадыг арилгах хойшлуулшгүй ажил гүйцэтгүүлэх.

5. Дор дурдсанаас бусад тохиолдолд нийтээр амрах баярын болон долоо хоног бүрийн амралтын өдөр ажил олгогчийн санаачлагаар ажиллуулахыг хориглоно:

5.1. энэ журмын 4.1-4.4-т заасан тохиолдол;

5.2. тасралтгүй ажиллагаатай үйлдвэрлэл, хүн амын үйлчилгээний болон хойшлуулшгүй засвар, ачиж буулгах ажил гүйцэтгүүлэх.

Хоёр.Нэмэгдэл хөлс тооцох аргачлал

(Энэ хэсгийг Засгийн газрын 2022 оны 490 дүгээр тогтоолоор нэмсэн бөгөөд үүнийг 2023-1-1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө)

1.Илүү цагаар, долоо хоногийн амралтын өдрөөр ажилласан төрийн албан хаагчийг нөхөн амруулаагүй бол түүний дундаж цалин хөлсийг нэг аравны тав дахин (нэг аравны таваас дээш байхыг хамтын гэрээ, хамтын хэлэлцээр, хөдөлмөрийн гэрээнд тусган зохицуулж болно.) нэмэгдүүлэн тооцно.

2.Нийтээр амрах баярын өдөр ажилласан төрийн албан хаагчийг нөхөн амруулаагүй бол түүний дундаж цалин хөлсийг хоёр (хоёроос дээш байхыг хамтын гэрээ, хамтын хэлэлцээр, хөдөлмөрийн гэрээнд тусган зохицуулж болно.) дахин нэмэгдүүлэн тооцно.

3.Шөнийн цагаар ажилласан төрийн албан хаагчийг нөхөн амруулаагүй бол түүний дундаж цалин хөлсийг нэг аравны хоёр (нэг аравны хоёроос дээш байхыг хамтын гэрээ, хамтын хэлэлцээр, хөдөлмөрийн гэрээнд тусган зохицуулж болно.) дахин нэмэгдүүлэн тооцно.

4.Албан хаагчийг илүү цагаар, долоо хоногийн амралтын болон нийтээр амрах баярын өдөр шөнийн цагт ажиллуулсан бол энэ хэсгийн 1, 2-т заасан нэмэгдэл хөлс дээр шөнийн цагийн нэмэгдэл хөлсийг нэмж олгоно.

5.Албан хаагчийг ээлжийн хуваарийн дагуу шөнийн цагт ажиллуулбал шөнийн цагийн нэмэгдэл хөлсийг олгоно. Ээлжээр ажилладаг албан хаагчийн ээлж долоо хоногийн амралтын болон нийтээр амрах баярын өдөр таарсан бол долоо хоногийн амралтын болон нийтээр амрах баярын өдрөөр ажилласны нэмэгдэл хөлс олгохгүй.

6.Нэмэгдэл хөлс тооцох, олгохтой холбоотой зохицуулалтыг байгууллагын хөдөлмөрийн дотоод хэм хэмжээнд тусган зохицуулж болно.

Гурав. Нэмэгдэл хөлс олгох

1. Төрийн албан хаагч энэ журмын хавсралтаар баталсан “Нэмэгдэл хөлс тооцож олгох хуудас”-ны дагуу илүү цагаар, долоо хоногийн амралтын өдрөөр, нийтээр амрах баяр ёслолын өдрөөр, шөнийн цагаар ажилласан үндэслэл, гүйцэтгэсэн ажлын гол агуулга, нэмэгдүүлсэн цалин хөлсний тооцоог нэгжийн даргаар хянуулж баталгаажуулсны үндсэн дээр байгууллагын дарга зөвшөөрөл олгосны дараа санхүүд хүргүүлнэ.

2. Нэмэгдэл хөлсийг төрийн албан хаагчийн илүү цагаар, долоо хоногийн амралтын өдрөөр, нийтээр амрах баяр ёслолын өдрөөр, шөнийн цагаар ажилласны дараа сарын цалин хөлстэй хамт тооцож олгоно.

3. Илүү цагаар, долоо хоногийн амралтын өдрөөр, нийтээр амрах баяр ёслолын өдрөөр, шөнийн цагаар ажилласны нэмэгдэл хөлс тооцох цаг нь 4.1-т зааснаас бусад тохиолдолд тухайн сарын ажлын цагийн 10 хувиас хэтрэхгүй байна. Тухайлбал, 8 дугаар сарын ажлын цаг 160 гэж үзвэл тухайн сард нэмэгдэл хөлс тооцогдох цаг нь 16-аас илүүгүй байна.

4. Төрийн албан хаагчид нэмэгдэл хөлс олгох журмын хавсралт хүснэгтийн үндэслэл хэсэгт 1.4.1-1.4.4, 1.5.1-1.5.2-т зааснаас тохирохыг сонгож бөглөнө. Ажлын товч агуулга гэсэн хэсэгт нэмэгдэл хөлс тооцох цагт гүйцэтгэсэн ажлын товч агуулгыг үндэслэл тус бүрээр бичнэ.

5.Ээлжийн хуваарийн дагуу ажилладаг ажилтан болон байгаль хамгаалагч, соёлын ажилтанд нэмэгдэл хөлс олгохдоо энэ хэсгийн 3 дахь заалтыг баримтлахгүй байж болно. Ингэхдээ Хөдөлмөрийн тухай хуулийн 84.4-т заасныг баримтална. (Энэ заалтыг Засгийн газрын 2020 оны 151 дүгээр тогтоолоор нэмж, Засгийн газрын 2022 оны 490 дүгээр тогтоолоор өөрчлөн найруулсан бөгөөд үүнийг 2023-1-1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө. Засгийн газрын 2023 оны 242 дугаар тогтоолоор өөрчлөлт орсон бөгөөд үүнийг 2024.01.01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө)

Дөрөв. Бусад

1. Нарийн төвөгтэй ажилбар болон анхаарал төвлөрөл шаардах ажил гүйцэтгэдэг эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний зарим албан хаагчийг шөнийн цагаар ажиллуулсан тохиолдолд мэргэжлийн алдаа гаргах, үйлчлүүлэгчийн амь нас, эрүүл мэндэд үүсэх эрсдлээс сэргийлж, түүнийг нөхөн амруулна. Зайлшгүй шаардлагатай тохиолдолд шөнийн цагаар ажилласан төрийн албан хаагчтай зөвшилцсөний үндсэн дээр түүнийг үргэлжлүүлэн ажиллуулж, энэ журмын дагуу нэмэгдэл хөлсийг тодорхойлно.

2. Төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллагад ажиллаж байгаа эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч алсын болон төрөлжсөн мэргэжлийн дуудлагаар явж эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлсэн бол түүний албан тушаалын сарын үндсэн цалингийн 5 хүртэл хувиар тооцож дуудлагаар явсан тохиолдол бүрт нэмэгдэл хөлс олгоно. Алсын болон төрөлжсөн мэргэжлийн дуудлагаар явж эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлсэн үед тооцох нэмэгдэл хөлсийг дуудлагын зай болон замын бартаанаас хамааруулж олгох зохицуулалтыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн баталж, дагаж мөрдүүлнэ.

3. Ерөнхий боловсролын сургуулийн багшид анги даасны 10 хувь, кабинет, лаборатори хариуцан ажилласны 5 хувь, цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн заах аргын нэгдлийн ахлагчид заах аргын нэгдэл удирдсаны 5 хувийн нэмэгдэл хөлс тус тус тооцож олгоно.

-----000-----

Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид

нэмэгдэл хөлс олгох журмын хавсралт

НЭМЭГДЭЛ ХӨЛС ТООЦОЖ ОЛГОХ ХУУДАС

20... оны ... дугаар

сарын ...-ний өдөр

Дугаар

_____ажилтай _____ овогтой _____-д 20 оны ...

дугаар сард цагийн нэмэгдэл хөлс олгохыг зөвшөөрөв.

Хөлс	Нэмэгдэл	Үндэслэл (журмын 4.1-4.4, 5.1-5.2 дахь заалтын аль нь болохыг бичих)	Ажлын товч агуулга	Ажилласан огноо, цаг, минут	Нэмэгдүүлсэн цалин хөлсний тооцоо	Тухайн ажлыг гүйцэтгэсэн байршил	Баталгаажуулсан нэгжийн дарга
	1	2	3	4	5	6	7
.	Илүү цаг ажилласан			1.	1.	1.	
.	Долоо хоногийн амралтын өдрөөр ажилласан			1.	1.	1.	
.	Нийтээр амрах баяр ёслолын өдөр ажилласан			1.	1.	1.	
.	Шөнийн цагаар ажилласан			1.	1.	1.	
.	Бүгд						

Зөвшөөрсөн: Төсвийн шууд захирагч / /

Хянасан: Нэгжийн дарга / /

Тооцоо хийх хүсэлт гаргасан: Төрийн албан хаагч / /

Засгийн газрын 2018 оны 382 дугаар

тогтоолын 3 дугаар хавсралт

ТӨРИЙН АЛБАН ХААГЧИД ДОКТОРЫН ЗЭРЭГ, ПРОФЕССОР

ЦОЛНЫ НЭМЭГДЭЛ ОЛГОХ ЖУРАМ

1. Төрийн албыг өндөр мэдлэгтэй хүний нөөцөөр бэхжүүлэх, төрийн албан хаагчид эрдэм боловсролоо дээшлүүлж байх сонирхлыг дэмжих зорилгоор төрийн албан хаагчид докторын зэрэг, профессор цолны нэмэгдэл олгоход энэ журмыг мөрдөнө.

2. Их, дээд сургууль, коллеж, мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төв, эмнэлгийн тусламж үйлчилгээний тухай хууль тогтоомжоор заасан байгууллагад сургалт, эрдэм шинжилгээ, туршилтын ажил эрхэлдэг, эрдэм шинжилгээний байгууллагад болон судалгаа шинжилгээ, туршилтын үндсэн үйлдвэрлэл дээр ажилладаг эрдмийн зэрэг, цолтой төрийн албан хаагчид албан тушаалын сарын үндсэн цалингаас дор дурдсан хувиар бодож сар бүр нэмэгдэл олгож байна:

Эрдмийн зэрэг, цол	Албан тушаалын сарын үндсэн цалингаас бодох хувь
Шинжлэх ухааны доктор зэрэг	20
Профессор цол	10
Боловсролын доктор зэрэг	15
Дэд профессор цол	5

3. Докторын зэрэг, профессор цолны нэмэгдлийг төрийн албан хаагчид давхардуулан олгож болно.

4. Энэ журмын 2-т зааснаас бусад төрийн байгууллагад ажиллаж байгаа шинжлэх ухааны докторын зэрэгтэй төрийн албан хаагчид албан тушаалын сарын үндсэн цалингийн 15 хувиар, боловсролын докторын зэрэгтэй төрийн албан хаагчид албан тушаалын сарын үндсэн цалингийн 10 хувиар тооцож, докторын зэргийн нэмэгдэл олгоно.

5. Профессор, дэд профессор цолны нэмэгдлийг зөвхөн энэ журмын 2-т заасан ажил, үүрэг гүйцэтгэж байгаа төрийн албан хаагчид олгоно. Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын холбогдох дүрэм, журмаар зөвшөөрөгдсөн байгууллагаас олгосон профессор, дэд профессор цолны нэмэгдэл хамаарна.

6. Докторын зэрэг, профессор цолны нэмэгдлийг тухайн албан хаагчийн албан тушаалын үндсэн ажил үүрэг эрхлэн гүйцэтгэсэн хугацаанд нь бодож олгоно.

7. Докторын зэрэг, профессор цолны нэмэгдлийг тухайн байгууллага жил бүрийнхээ төсөвт тусгаж олгоно.

-----oOo-----

**Засгийн газрын 2018 оны 382 дугаар
тогтоолын 4 дүгээр хавсралт
ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АЛБАН ХААГЧИД УР ЧАДВАРЫН
НЭМЭГДЭЛ ОЛГОХ НИЙТЛЭГ ЖУРАМ**

1. Төрийн үйлчилгээний албан хаагчийн ажил гүйцэтгэх чадвар, ажлын арга барил, идэвх санаачилгыг нь дэмжиж, үр бүтээлтэй ажиллуулах зорилгоор ур чадварын нэмэгдэл олгоход энэ журмыг мөрдөнө.

2. Төрийн үйлчилгээний албан хаагчид ур чадварын нэмэгдэл олгох асуудлыг тухайн байгууллагын төсвийн шууд захирагч шийдвэрлэнэ.

3. Төрийн үйлчилгээний байгууллагын удирдах, гүйцэтгэх, туслах албан хаагчид төрийн үйлчилгээний албан тушаал эрхэлж байх хугацаанд нь ур чадварын нэмэгдэл олгох асуудлыг энэ журмын 4-т заасан шалгуур үзүүлэлтийн дагуу албан тушаалын сарын үндсэн цалингаас 10-25 хувиар тооцож, сар бүр олгоно.

4. Энэ журмыг үндэслэн тухайн салбар, мэргэжлийн онцлогийг харгалзан төрийн үйлчилгээний албан хаагчид ур чадварын нэмэгдэл олгох шалгуур үзүүлэлтийг салбарын асуудал хариуцсан Засгийн газрын гишүүн нь хөдөлмөр, нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, санхүүгийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнтэй хамтран тогтооно.

5. Ур чадварын нэмэгдлийг тухайн байгууллага жил бүрийнхээ төсөвт тусгаж олгоно.

-----o0o-----

Засгийн газрын 2018 оны 382 дугаар

тогтоолын 5 дугаар хавсралт

ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АЛБАН ХААГЧИД МЭРГЭШЛИЙН

ЗЭРГИЙН НЭМЭГДЭЛ ОЛГОХ НИЙТЛЭГ ЖУРАМ

1. Төрийн үйлчилгээний албан хаагчийн мэргэжлээрээ зөвлөгөө өгөх, бие даан мэргэжлийн санал, дүгнэлт гаргах, сургалт явуулах, мэргэжлийн түвшинд бие даасан бүтээл хийж олны хүртээл болгох зэргээр мэргэжлийн түвшинг нь дээшлүүлэх, урамшуулах зорилгоор мэргэшлийн зэргийн нэмэгдэл олгоход энэ журмыг мөрдөнө.

2. Төрийн үйлчилгээний албан хаагчийг мэргэжлийнхээ дагуу тухайн албан тушаал эрхэлж байх хугацаанд мэргэшлийн зэргийн нэмэгдэл олгох шалгуур үзүүлэлтийг үндэслэн албан тушаалын сарын үндсэн цалингаас дор дурдсан хувиар бодож сар бүр олгоно:

Төрийн үйлчилгээний албан хаагч				Албан тушаалын сарын үндсэн цалингаас бодох хувь
Мэргэшлийн зэрэг тогтоогдсон төрийн үйлчилгээний бусад албан тушаал (Засгийн газрын 2020 оны 151 дүгээр тогтоолоор өөрчилсөн)	Сургуулийн нийгмийн ажилтан, архивын ажилтан, эмнэлгийн мэргэжилтэн	Эрдэм шинжилгээний байгууллагын эрдэм шинжилгээний ажилтан	Цэцэрлэгийн багш, арга зүйч, ерөнхий боловсролын сургуулийн багш, сургалтын менежер, албан бус боловсролын болон мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын багш	
I зэрэг	Зөвлөх	Тэргүүлэх	Зөвлөх	20
II зэрэг	Тэргүүлэх	Ахлах	Тэргүүлэх	15
III зэрэг	Ахлах	Дэд	Заах аргач	10

3. Төрийн үйлчилгээний албан хаагчид мэргэшлийн зэрэг, зэргийн нэмэгдэл олгох асуудлыг тухайн байгууллагын төсвийн шууд захирагч шийдвэрлэнэ.

4. Хуульд өөрөөр заагаагүй бол төрийн үйлчилгээний албан хаагчийн мэргэшлийн зэргийг 5 жил тутам шинэчлэн тогтооно.

5. Эрдмийн зэрэг, цолны нэмэгдэл авдаг төрийн үйлчилгээний албан хаагчид мэргэшлийн зэргийн нэмэгдлийг давхардуулан олгож болно.

6. Хуульд өөрөөр заагаагүй бол төрийн үйлчилгээний албан хаагчид мэргэшлийн зэргийн нэмэгдлийг зөвхөн тухайн мэргэжлээрээ ажиллаж байгаа хугацаанд нь олгоно.

7. Энэ журмын 2-т заасан мэргэшлийн зэрэг, зэргийн нэмэгдэл олгоход тавигдах шалгуур үзүүлэлтийг салбарын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн нь хөдөлмөр, нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, санхүүгийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнтэй хамтран тогтооно.

8. Дэмжих, туслах чиг үүрэгтэй төрийн үйлчилгээний албан хаагчид мэргэшлийн зэргийн нэмэгдэл олгоход тавигдах шалгуур үзүүлэлтийг хөдөлмөр, нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн тогтооно. (Энэ заалтыг Засгийн газрын 2020 оны 151 дүгээр тогтоолоор хассан)

9. Мэргэшлийн зэргийн нэмэгдлийг тухайн байгууллага жил бүрийнхээ төсөвт тусгаж олгоно.

-----000-----